



УЛСЫН ИХ ХУРЛЫН
ГИШҮҮН Х.БААСАНЖАРГАЛ
ТАНАА

**МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН
ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР**

Төрийн ордон, Жанжин Д.Сүхбаатарын талбай,
6 дугаар хороо, Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, 14201

Утас: (976-51) 26 08 17, Факс: (976-51) 26 24 08,

Цахим шуудан: info@cabinet.gov.mn,

Цахим хуудас: www.cabinet.gov.mn

2025-09-12 № 187/2495
танай _____-ны № _____-т

Асуулгын хариу хүргүүлэх тухай

Танаас Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн хэрэгжилтийн талаар Монгол Улсын Ерөнхий сайдад тавьсан асуулгын хариуг Улсын Их Хурлын Хяналт шалгалтын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2 дахь хэсэгт заасны дагуу хүргүүлж байна.

Хавсралт 0.6 хуудастай.

МОНГОЛ УЛСЫН САЙД,
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ
ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА



С.БЯМБАЦОГТ

000255014828



Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын
2025 оны 09 дугаар сарын 12-ны
өдрийн 101/24/25 тоот албан
бичгийн хавсралт

**УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН Х.БААСАНЖАРГАЛААС ХӨГЖЛИЙН БОДЛОГО,
ТӨЛӨВЛӨЛТ, ТҮҮНИЙ УДИРДЛАГЫН ТУХАЙ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙН
ТАЛААР МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙДАД ТАВЬСАН АСУУЛГЫН ХАРИУ**

“Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого батлах тухай” Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар баталсан ““Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагаа”-ны зорилт 4.1-д “Макро эдийн засгийн тогтвортой орчныг бүрдүүлж, дундаж давхаргыг нийгмийн зонхилох бүлэг болгоно.” гэж заасан.

Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газраас ““Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагаа”-ны хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн. Үнэлгээний тайланд дурдсанаар дээрх 4.1 дэх зорилтын хүрээний 31 үйл ажиллагааны хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхэд 63.87 хувийн биелэлттэй гарсан байна. Үүнээс “Эдийн засаг” зорилгын хүрээнд 6 зорилтын хүрээний 190 үйл ажиллагааны хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхэд 165 үйл ажиллагааны хэрэгжилт 55.82 хувьтай буюу “эрчимжүүлэх шаардлагатай” гэж үнэлэгдсэн байна¹.

“Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай” Улсын Их Хурлын 2024 оны 21 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан “Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн тэргүүлэх чиглэлийн “Хүний хөгжлийн бодлого”-ын хүрээнд “Хөгжлөөс хэнийг ч орхигдуулахгүй байх зарчмыг баримтлан хөгжих, суралцах, ая тухтай амьдрах орчныг бүрдүүлж, чинээлэг, баялагтаа эзэн, эрдэм боловсролтой, эрүүл монгол хүнийг хөгжүүлнэ.” гэж тодорхойлсон. Энэ хүрээнд гэр бүл, хүн амын онцлогт нийцсэн бодлогыг хэрэгжүүлэх, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, иргэдийн нийгмийн баталгааг хангах замаар өрхийн орлогыг нэмэгдүүлж, эрдэм боловсролтой, эрүүл монгол хүнийг бий болгох зорилгыг дэвшүүлсэн байна.

Түүнчлэн, тэргүүлэх чиглэлийн “Эдийн засгийн бодлого”-ын хүрээнд “Зах зээл дэх төрийн оролцоог бууруулж, бизнес, хөрөнгө оруулалтын орчныг сайжруулан, төр, хувийн хэвшлийн түншлэлийг бэхжүүлж, олон тулгуурт, хүртээмжтэй, экспортын баримжаатай эдийн засгийг бэхжүүлнэ.” гэсэн эдийн засгийн эрх чөлөөг бий болгох зорилгыг тодорхойлсон бөгөөд энэ хүрээнд макро эдийн засгийн тогтвортой байдлыг хангах зорилтуудыг дэвшүүлсэн.

Дээрх зорилтуудыг хэрэгжүүлэх хүрээнд “Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөө батлах тухай” Улсын Их Хурлын 2024 оны 35 дугаар тогтоолын 1 дүгээр

¹ Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газар. (2025 он). “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагаа”-ны хэрэгжилтийн явцын тайлан.

хавсралтаар баталсан “Монгол Улсын хөгжлийн 2025 онд баримтлах бодлогын тэргүүлэх чиглэл”-ийн “Эдийн засгийн бодлого”-ын 1.1-т “Эдийн засгийн тогтвортой өсөлтийг хадгалж, өгөөжийг өрх бүрд хүргэнэ”, “Хүний хөгжлийн бодлого”-ын 3.4-т “Нийгмийн баталгааг сайжруулж, хүн амын бүлгийн онцлогт нийцсэн бодлогыг хэрэгжүүлнэ” гэж туссан.

“Монгол Улсын хөгжлийн 2026 оны төлөвлөгөө батлах тухай” Улсын Их Хурлын 2025 оны 48 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан “Монгол Улсын хөгжлийн 2026 онд баримтлах бодлогын тэргүүлэх чиглэл”-д “Хүн төвтэй” хөгжлийн үзэл санаанд нийцсэн “Эдийн засгийн эрх чөлөө”-г цогцлоож, эдийн засгийн эрх чөлөөний реформ, төсвийн зардлын реформ, төрийн албаны реформ, үндэсний баялгийн сан, төрийн өмчит компанийн засаглалын реформыг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн.

Мөн “Хүний хөгжлийн бодлого” хэсэгт тогтвортой хөгжлийн зорилгын хэрэгжилтийг эрчимжүүлж, “Хөгжлөөс хэнийг ч орхигдуулахгүй байх” зарчмыг баримтлан, хүн бүрд саадгүй, хүртээмжтэй, аюулгүй, эрүүл орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлж, хөдөлмөрийн зах зээлд өрсөлдөх чадварыг хамгаалах, дэмжих бодлогыг хэрэгжүүлж, ядуурал, тэгш бус байдлыг бодитой бууруулж, чинээлэг, баялагтаа эзэн, эрдэм боловсролтой, эрүүл монгол хүнийг хөгжүүлэх бодлогын чиглэлийг тодорхойлсон.

1. “Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл” болон түүний хавсралтаар баталсан “Монгол Улсын 2021-2025 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөр”-ийн хэрэгжилтийн үнэлгээ, тайланг Улсын Их Хуралд хүргүүлэх хүрээнд:

Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газраас “Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл батлах тухай” Улсын Их Хурлын 2020 оны 23 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар батлагдсан “Монгол Улсын 2021-2025 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөр”-ийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн.

Үнэлгээний тайланг 2025 оны 09 дүгээр сарын 10-ны өдрийн Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж, Улсын Их Хуралд танилцуулахаар хүргүүлсэн болно.

2. “Монгол Улсын 2021-2025 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөр”-ийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн хүрээнд:

Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээг “Журам шинэчлэн батлах тухай” Засгийн газрын 2020 оны 12 дугаар сарын 09-ний өдрийн 206 дугаар тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ыг баримтлан хийж байсан бөгөөд бодлогын зорилго, зорилтын хэрэгжилтийн ерөнхий дүнг гаргахдаа уг журамд заасны дагуу зорилт, арга хэмжээ бүрийн хэрэгжилтийн арифметик дунджаар тооцдог байсан.

“Журам шинэчлэн батлах тухай” Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ыг Засгийн газрын 2025 оны 01 дүгээр сарын 29-ний өдрийн 43 дугаар тогтоолоор

шинэчлэн баталсан. Уг журмыг шинэчлэн боловсруулах дараах шаардлагууд үүссэн. Үүнд:

-Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.4 дэх “Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, дүгнэлт гаргах журмыг Засгийн газар батална” заалтыг 2021 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн хуулиар хүчингүй болгосон;

-Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуульд заасан хөгжлийн бодлогын хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, тайлагнах цаглавар хоорондоо зөрүүтэй байгаа нь хяналт шинжилгээ, үнэлгээ хийх, тайлагнах үйл ажиллагаанд хүндрэл учруулж байгаа;

-Хяналт шинжилгээ болон үнэлгээ хийх, байгууллагын үйл ажиллагааг төлөвлөх, тайлагнах, дүгнэх үйл ажиллагааны хамрах хүрээ, аргачлалыг гарцад бус үр дүнд чиглэсэн байхаар ялгаатай зохицуулах шаардлага үүссэн;

-Хөгжлийн бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, шийдвэр болон байгууллагын үйл ажиллагааг үнэлж, дүгнэх, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх харилцааг хамтад нь нэг журмаар зохицуулж байсныг салгаж, олон улсын арга аргачлалд нийцүүлэх хэрэгцээ шаардлага бий болсон;

-Одоо мөрдөж буй журамд үнэлгээний тогтолцоо, төрөл, нэр томьёо, арга зүй, оролцогч талуудын эрх үүрэг гэх мэт харилцааг тодорхой зохицуулаагүй байна. Иймд бодлогын үнэлгээ хийх тогтолцоог бий болгох, эрх зүйн зохицуулалтыг сайжруулах, олон улсын стандартад нийцүүлэх шаардлага үүссэн.

“Монгол Улсын 2021-2025 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөр”-ийн хэрэгжилтийг “Журам батлах тухай” Засгийн газрын 2025 оны 43 дугаар тогтоолоор баталсан журмын дагуу үнэлсэн. Үнэлгээний дүнгээс үзвэл:

“Монгол Улсын 2021-2025 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөр”-т нийт 336 төсөл, арга хэмжээ батлагдсанаас санхүүжилтийн эх үүсвэр шийдвэрлэгдсэн 150, техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөл боловсруулах шаардлагатай 98, санхүүжилтийн эх үүсвэр шийдвэрлэх шаардлагатай 88 төсөл, арга хэмжээ тусгагдсан бөгөөд үнэлгээний тайланд дурдсанаар тус хөтөлбөрт туссан нийт 336 төсөл, арга хэмжээний 176 төсөл, арга хэмжээ нь 52 хувийн хэрэгжилттэй, 59 төсөл, арга хэмжээ нь 18 хувийн хэрэгжилттэй, 101 төсөл, арга хэмжээ нь 30 хувьтай буюу хэрэгжиж эхлээгүй².

Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.3 дахь хэсэгт заасны дагуу “Монгол Улсын 2021-2025 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөр”-т мэдээллийг цуглуулах, ангилах, нэгтгэх, зорилтын болон биелэлтийн үр нөлөө, гадаад, дотоод хүчин зүйлийн нөлөөлөл, төлөвлөлт, хэрэгжилтийн харилцан хамаарал болон биелэлтийн түвшинг үнэлэх, мөн бодлогын баримт бичгийн төлөвлөлт, хэрэгжилтийг сайжруулах тодорхой санал боловсруулах чиглэлээр цогц хяналт-шинжилгээ, үнэлгээг шат дараатайгаар хийж гүйцэтгэсэн байна.

² Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газар. (2025 он). “Монгол Улсын 2021-2025 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөр”-ийн хэрэгжилтийн үнэлгээний тайлан.

3. Аймаг, нийслэл, хотын хөгжлийн төлөвлөгөө нь улсын жилийн төлөвлөгөөнд суурилсан, тухайн нутаг дэвсгэрт хэрэгжүүлэх төсөв, санхүүгийн эх үүсвэрийг бүрэн, цогцоор нь тусгасан эсэхэд хяналт тавьж ажилласан талаар:

Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.11 дэх хэсэгт аймаг, сум, нийслэл, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хөгжлийн бодлого, төлөвлөлтийн талаарх чиг үүргийг тусгахдаа “Аймаг, нийслэл, хотыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, Аймаг, нийслэл, хотын хөгжлийн жилийн төлөвлөгөө зэрэг бодлогын баримт бичгийг хэлэлцэн, батлах, эсхүл буцаах”-аар заасан.

Эдийн засаг, хөгжлийн яамнаас “Монгол Улсыг болон аймаг, нийслэл, хотыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл боловсруулах аргачлал”, “Аймаг, нийслэл, хотын жилийн төлөвлөгөө боловсруулах аргачлал”-ыг тус тус баталж, орон нутгийн хөгжлийн бодлого, төлөвлөгч нарт аргачлалуудыг танилцуулах, мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгөх ажлыг 2023 оноос хойш жил бүр тогтмол зохион байгуулж байна.

Түүнчлэн, аймаг, нийслэлийн Засаг даргыг Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.10.1-д заасан бодлогын баримт бичгийг боловсруулахад Эдийн засаг, хөгжлийн яамнаас холбогдох баримт бичгийн төсөлд батлагдсан аргачлал, хүргүүлсэн зааврын дагуу боловсруулагдсан эсэх, бодлогын баримт бичгийн уялдаа, холбоо болон бусад асуудлаар санал, зөвлөмжийг хүргүүлэн ажиллаж байна.

Цаашид хөгжлийн бодлого, төлөвлөгч нарыг тогтмол чадавхжуулах, мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлэх ажлуудыг тогтмол зохион байгуулах, бодлогын баримт бичгүүдийн уялдаа холбоог хянах, холбогдох талуудаас санал өгөх процессыг хялбаршуулах, хурдасгах чиглэлд мэдээллийн цахим системийг хөгжүүлж, ашиглах хэрэгцээ, шаардлага байна.

4. Монгол Улсын 2026 оны төсвийн тухай хуулийн төслийн талаар:

“Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг боловсруулах журам”-ыг “Журам шинэчлэн батлах тухай” Засгийн газрын 2022 оны 470 дугаар тогтоолоор шинэчлэн баталсан. Уг журмаар хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг тус бүрийн онцлогт нийцсэн аргачлалаар боловсруулах нөхцөлийг бүрдүүлсэн. Үүнд:

1. “Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөө боловсруулах аргачлал”-ыг үр дүнд суурилсан арга зүйд тулгуурлан боловсруулж, Эдийн засаг, хөгжлийн сайдын 2022 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн А/167 дугаар тушаалаар³ баталсан;

2. “Аймаг, нийслэл, хотын жилийн төлөвлөгөө боловсруулах аргачлал”-ыг боловсруулж, Монгол Улсын Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын 2023 оны 05 дугаар сарын 08-ны өдрийн А/26 дугаар тушаалаар⁴ баталсан;

³ Эдийн засаг, хөгжлийн яам. (2022 он). Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөө боловсруулах аргачлал.

⁴ Эдийн засаг, хөгжлийн яам. (2023 он). Аймаг, нийслэл, хотын жилийн төлөвлөгөө боловсруулах аргачлал.

3. “Хөгжлийн зорилтот хөтөлбөр боловсруулах аргачлал”-ыг боловсруулж Монгол Улсын Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын 2023 оны 05 дугаар сарын 08-ны өдрийн А/25 дугаар тушаалаар⁵ баталсан;

4. “Монгол Улсыг болон аймаг, нийслэл, хотыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл боловсруулах аргачлал”-ыг боловсруулж, Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын 2025 оны 07 дугаар сарын 28-ны өдрийн А/13 дугаар тушаалаар⁶ баталсан.

Дээрх аргачлалуудад баримт бичиг тус бүрийг боловсруулах үе шат, дарааллыг тодорхойлж, урт хугацааны хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэхэд чиглэсэн, улс, салбар, салбар хооронд болон бүс, орон нутгийн уялдааг хангасан үр дүнг нөөцөд суурилан боловсруулахад чиглэсэн болно.

Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.4 хэсэгт “Үндэсний хөгжлийн бодлого, төлөвлөлтийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын чиг үүрэг”-ийг тогтоож өгсөн бөгөөд 9.4.3 дахь заалтад “...улсын төсвийн төсөл Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөнд нийцэж байгаа эсэх асуудлаар зөвшөөрөл өгөх” чиг үүргийг гүйцэтгэхээр, мөн төсвийн төсөл боловсруулахад тавигдах шаардлагыг Төсвийн тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1.8 дахь заалтад “Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөнд суурилсан байх”-аар тус тус заасан.

Эдийн засаг, хөгжлийн яамнаас улсын төсвийн төсөлд зөвшөөрөл өгөхдөө Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөнд тусгагдсан төсөл, арга хэмжээ болон төсвийн төслийн уялдаа холбоог авч үздэг бөгөөд тэдгээрийн нийцэл 2022 онд 36.1 хувьтай, 2023 онд 47.1 хувьтай, 2024 онд 71.0 хувьтай, 2025 онд 92.0 хувьтай тус тус гарсан.

Монгол Улсын 2026 оны төсвийн тухай хуулийн төсөл нь “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичигтэй 100.0 хувийн, “Шинэ сэргэлтийн бодлого”-той 91.5 хувийн, “Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-тэй 100.0 хувийн нийцэлтэй байна. Түүнчлэн, Монгол Улсын хөгжлийн 2026 оны төлөвлөгөөний бодлогын тэргүүлэх чиглэлтэй агуулгын хувьд 100.0 хувь, Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээтэй 60.0 хувийн нийцэлтэй байгаа талаар Эдийн засаг, хөгжлийн яамнаас тооцоолсон.

5.Бодлогын баримт бичгийн үр дүн, шалгуур үзүүлэлтийн талаар:

Улсын Их Хурлаас 2019 оны 11 дүгээр сарын 14-ний өдөр баталсан Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөөр Хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 7-д “Хөгжлийн бодлого, төлөвлөлт тогтвортой байна.” гэж заасан бөгөөд Улсын Их Хурлаас 2020 онд Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг хэлэлцэж, баталсан.

⁵ Эдийн засаг, хөгжлийн яам. (2023 он). Хөгжлийн зорилтот хөтөлбөр боловсруулах аргачлал.

⁶ Эдийн засаг, хөгжлийн яам. (2025 он). Монгол Улсыг болон аймаг, нийслэл, хотыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл боловсруулах аргачлал.

Энэ хууль батлагдсанаар Монгол Улсын урт, дунд, богино хугацааны хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгүүд тогтвортой, нэгдмэл цогц, залгамж чанартай, харилцан уялдаатай хэрэгжих эрх зүйн орчин бүрдсэн. Тухайлбал, “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, “Шинэ сэргэлтийн бодлого”, “Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”, “Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр” зэрэг дунд хугацааны төлөвлөлтийн баримт бичиг, богино хугацааны төлөвлөлтийн баримт бичиг буюу “Монгол Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөө”-г Улсын Их Хурлаар батлуулан хэрэгжүүлж байна.

Түүнчлэн, эдгээр баримт бичгүүдийг салбар хооронд болон бүс, орон нутгийн түвшинд уялдуулан төлөвлөх, нэгдсэн удирдлагаар хангах чиг үүрэг бүхий Эдийн засаг, хөгжлийн яамыг байгуулж, тус яамнаас дунд хугацааны хөгжлийн зорилго, зорилтыг хэрэгжүүлэх зорилгоор Монгол Улсын хөгжлийн 2023, 2024, 2025, 2026 оны төлөвлөгөөний төслийг боловсруулж, Улсын Их Хурлаар батлуулсан.

Үр дүнд суурилсан төлөвлөлтийн S.M.A.R.T (Specific-Тодорхой, Measurable-Хэмжигдэхүйц, Achievable-Бодитой, Relevant-Хамааралтай, Time bound-Цаг хугацаатай) зарчмыг баримтлан, “Үндэсний”, “Салбарын”, “Төсвийн ерөнхийлөн захирагчийн”, “Хөтөлбөрийн” гэсэн 4 түвшний үр дүнг хангахад чиглэсэн тэдгээрт хүрэх арга зам, хэмжих шалгуур үзүүлэлт, суурь болон зорилтот түвшин, шаардагдах хөрөнгийн хэмжээг төлөвлөхөд чиглэсэн болно.

Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.6 дахь заалтад “Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл” гэж Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэхэд чиглэсэн, Хөгжлийн зорилтот хөтөлбөрт нийцүүлсэн улс, салбар, салбар хооронд болон бүс, орон нутгийн уялдааг хангасан зорилго, зорилт, хүрэх үр дүн, нөөцөд суурилан боловсруулсан төсөл, арга хэмжээг агуулсан улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөр, тоон болон чанарын шалгуур үзүүлэлт бүхий дунд хугацааны нэгдсэн төлөвлөлтийн баримт бичиг” байхаар тодорхойлсон.

Эдийн засаг, хөгжлийн яамнаас “Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл” нь энэ онд дуусгавар болж байгаатай холбогдуулан дээрх хуулийн 14 дүгээр зүйлд заасны дагуу “Монгол Улсыг 2026-2030 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”-ийн төслийг “Монгол Улсыг болон аймаг, нийслэл, хотыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл боловсруулах аргачлал” болон мөн хуульд заасан цаглаврын дагуу боловсруулж байна. Түүнчлэн, “Үндэсний”, “Салбарын”, “Төсвийн ерөнхийлөн захирагчийн”, “Хөтөлбөрийн” гэсэн 4 түвшний үр дүн, шалгуур үзүүлэлт, зорилтот түвшнийг тодорхойлон ажиллаж байна.

Урт, дунд, богино хугацааны хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг болон Улсын төсвийн төслийн уялдааг сайжруулахын тулд Монгол Улсын төсвийн тухай хуулийн 1 дүгээр хавсралтаар баталдаг Төсвийн ерөнхийлөн захирагч бүрийн тухайн онд хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлтийг сайжруулах, оролцогч талуудын энэ талаарх мэдлэг, ойлголтыг дээшлүүлэх шаардлага үүсэж байна. Энэ хүрээнд Эдийн засаг, хөгжлийн яамнаас төрийн албан хаагчдад үр дүнд суурилсан төлөвлөлтийн сургалтуудыг тогтмол зохион байгуулж байна.

---o0o---